



Арлингтоны сонгогчид 11-р сарын 5-нд 83.98 сая долларын сургуулийн бонд батлах эсэхийг шийднэ. **Энэ нь манай сурагчид, багш ажилчид, сургуулиудын ирээдүйд чухал хөрөнгө оруулалт юм.** Тус бонд нь манай сургуулиуд аюулгүй, бүрэн ажиллагаатай, хувьсан өөрчлөгдөж буй хүн амын хэрэгцээг хангаж чадамжтай байх боломжийг баталгаажуулах юм.



### Бүх Сургуулиудаа Засварлаж Арчлах

- **Тасралтгүй Арчилгаа:** Энэ бонд сургуулиудын арчилгааг чанаржуулснаар нийт 28,000+ гаруй сурагчид шууд үр ашиг хүртэнэ.
- **Томоохон дэд бүтцийн Төсөл:** Dorothy Hamm, Escuela Key, Hoffman-Boston, Jamestown, Oakridge, Williamsburg сургуулиудын дээвэр, агааржуулалтын системийг шинэчилнэ.



### Нийтэд тустай, бүх оршин суугчдад хүртээлтэй

- **Хүчирхэг сургуулийн тогтолцоо:** Энэ бонд нь одоогийн барилгуудын ашиглалтыг дээд хэмжээнд хүргэснээр урт хугацааны тогтвортой төлөвлөлтийн эхний алхам болно.
- **Томоохон төслүүд:** Арлингтоны Монтессори Улсын Сургуулийн зориулалтаар Legacy Career Төвийн барилгыг тохируулан ашиглах зэрэг чухал дэд бүтцийн төслүүдийг урагшлуулна.



### Сурагчдын өдөр тутмын хэрэгцээг дэмжих

- **Гал тогооны шинэчлэл:** Тус бондын хөрөнгөөр гал тогооны шинэчлэл хийснээр бид сурагчдадаа шинэ, шим тэжээлтэй хоолыг сургуулиуд дээр бэлдэх боломж олгох юм.
- **Томоохон Төслүүд:** Arlington Science Focus, Ashlawn, Barrett болон Carlin Springs сургуулиудын гал тогоог шинэчлэх.

Сургуулийн бонд **11 -5-ны саналын хуудаст** багтана.

Дараах 3 аргаар саналаа өгнө:

- **Эрт санал хураалт:** Арлингтоны тодорхой байршлуудад 11 сарын 2-ны Бямба хүртэл авна.
- **Шуудангаар:** 10 сарын 25-ны Баасан гарагаас өмнө шуудангаар санал өгөх хүсэлт гаргах.
- **Биечилж:** 11 сарын 5-ны өглөө 6-с оройн 7 цаг хүртэл сонгуулийн санал хураах байруудад.